

Түүхийн улсын олимпиадын II давааны 12-р ангийн сурагчийн сорил-2024

1. Эртний хүний оюун санааны ертөнцийг танин мэдэхэд аль сурвалж чухал үүрэгтэй вэ? (1 оноо)
 - a. Чулуун зэвсэг
 - b. Соёлт давхаргат суурин
 - c. Хадны зураг
 - d. Дархны газар
 - e. Агуйн суурин
2. Дээд палеолитын үеэс хүн, нийгмийн хөгжилд хүчтэй нөлөөлөх болсон хүчин зүйл аль вэ? (1 оноо)
 - a. Дэлхийн ихэнх бүс нутагт хүн тархан суусан явдал
 - b. Гал эзэмшиж, овгоор амьдрах болсон явдал
 - c. Ан агнуурт шинэ аргууд нэвтрэн хүн ам өссөн явдал
 - d. Чулуун зэвсэг үйлдвэрлэлд цуулалтын шинэ технологи нэвтэрсэн явдал
 - e. Хэл яриа үүссэн явдал
3. Дорнод аймгийн Чойбалсан сумын нутаг Овоот уулын неолитын суурингаас сөрлүүрт ясан жад олджээ. Энэ жадны үүрэг аль вэ? (1 оноо)
 - a. Гаршуулах амьтныг шархдуулж барих
 - b. Нөгөө овгийн этгээдтэй тулалдах
 - c. Загас агнуурт ашиглах
 - d. Шашин шүтлэгийн зан үйлд хэрэглэх
 - e. Овгийн ахлагч эрх мэдлийнхээ бэлгэ тэмдэг болгох
4. Шинэ чулуун зэвсгийн үеийн дэвшилд аль нь хамаарахгүй вэ? (1 оноо)
 - a. Гэрийн мал
 - b. Шавар сав урлал
 - c. Нэхмэл эдлэл
 - d. Овгийн байгууллын задрал
 - e. Газар тариалан
5. Хүрэл, түрүү төмрийн үеийн нийгмийн үндэс суурь аль вэ? (1 оноо)
 - a. Нүүдлийн мал аж ахуй
 - b. Нүүдэлчин овог аймгууд
 - c. Талын сурвалжит язгууртан
 - d. Эгэл жирийн нүүдэлчид
 - e. Хүчирхэг цэрэг эрс, дайчид
6. Сурвалжийн мэдээг уншаад асуултад хариулж бичнэ үү.
“Энэ үед Дунху хүчирхэгжин, Юэжи цэцэглэн мандаж байв” (Зөв хариулт бүр 1 оноо, нийт 4 оноо)
 - a. Энэ ямар сурвалжийн мэдээ вэ?
 - b. Энэ түүхийн зохиолыг хэн бичсэн бэ?.....
 - c. Энэ түүхийн зохиолыг хэзээ бичсэн бэ?
 - d. Энэ мэдээ хэдийд холбогдох вэ?
7. Хятаны угсаа гарвалыг зөв тодорхойлсон нь аль вэ? (1 оноо)
 - a. Хүннүгийн угсааны аймаг
 - b. IV зуунд түрэг, монгол хэлт аймгуудаас үүссэн
 - c. Дунхугийн салбар, Сяньби аймаг
 - d. Хожмын монголчуудтай угсаа гарвалын шууд холбоотой
 - e. Монгол хэлт, түрэгжсэн аймаг
8. “Ахын дуу”-г хэн зохиож дуулсан бэ? (1 оноо)
 - a. Муюн
 - b. Тугухунь
 - c. Таньшихуай
 - d. Шэлүнх
 - e. Амбагян

9. “Судрын чуулган”-д “...их том дуутай, ...гар нь баавгайн сарвуу шиг...” гэж хэнийг өгүүлсэн бэ? (1 оноо)
 a. Хайду b. Хабул c. Амбагай d. Хутула
10. Монголын нэгдсэн улс байгуулагдах түүхэн шаардлагад хамаарахгүй нь аль вэ? (1 оноо)
 a. Аймаг, улсуудын байнгын зөрчил, дайн самууныг зогсоох
 b. Зүрчидийн Алтан улсын дарлал, түрэмгийллийг зогсоох
 c. Нэг соёл, зан заншил, шашин шүтлэгийг бий болгох
 d. Нэгдмэл төрийн доор энх амгалан амьдрах
11. 1201 онд Жамухыг хаана Гүр хаанд өргөмжилсөн бэ? (1 оноо)
 a. Хорхонаг жубур b. Далан балжуд c. Онон мөрний эхэн d.Эргүнэ гол
12. 1216 онд Чингис хааны эсрэг ямар аймаг бослого гаргасан бэ? (1 оноо)
 a. Ойрад b. Хиргис c. Ойн иргэд d. Хорь Түмэд
13. Дараах өгүүлбэрээс зөв 2 өгүүлбэрийг дугуйлна уу. (Зөв хариулт бүр 1 оноо, нийт 2 оноо)
 a. Өгөдэй хааны үед умард Месопотам, Гүрж, Армяныг довтолж, Анатоли дахь Сельжукийн улсыг хараат болгов.
 b. 1235-1241 онд Монголын цэрэг баруун Европын зарим улс орнуудыг эрхшээлдээ оруулав.
 c. Өгөдэйг хаан өргөмжлөх хуралдайд 4000 гаруй элч төлөөлөгч ирж оролцов.
 d. Мөнх хааны үед шашны мэтгэлцээн зохион байгуулав.
14. XVI зууны II хагаст Ойрад, Хөх нуурт хэн ноёрхлоо тогтоосон бэ? (1 оноо)
 a. Батмөнх даян хаан b. Дарайсун Гүдэн хаан
 c. Түмэн засагт хаан d. Алтан хан
15. Дараах өгүүлбэрийг нөхөж бичнэ үү. (Зөв хариулт бүр 0.5 оноо, нийт 1 оноо)
 онд Ширээ цагаан нуур хэмээх газарт Занабазарт цол олгов.
16. Хүснэгтэд Манжийн эсрэг тэмцсэн цэргийн бослогод холбогдох мэдээллийг нөхөж бичнэ үү. (Зөв хариулт бүр 1 оноо, нийт 4 оноо)

Цэргийн бослого	Он	Хамрагдсан цэргийн тоо
Онолтоор удирдуулсан бослого	a.	b.
Энхтайванаар удирдуулсан бослого	c.	d.

17. 1911 оны 12 сарын 29-ний үйл явдлыг буруу өгүүлсэн зүйл аль вэ? (Зөв хариулт бүр 1 оноо, нийт 2 оноо)
 a. Монгол улсын тусгаар тогтнолыг зарлан тунхаглав
 b. VIII Богд Жавзандамба хутагтыг Монгол улсын шашин, төрийг хослон баригч хаанаар өргөмжлөв
 c. Монгол улсын оны цолыг Олноо өргөгдсөн хэмээв
 d. Төрийн 6 яамыг байгуулж, тэргүүн, дэд сайдыг тохоон томилов
 e. Их Хүрээг Нийслэл Хүрээ гэж нэрлэв

18. Дараах баримт бичгийг уншаад хариулж бичнэ үү.
 “Бүгд найрамдах улсын нутаг дэвсгэр 22 муж, Ар, Өвөр Монгол, Түвэд”. (Зөв хариулт бүр 1 оноо, нийт 3 оноо)
- Энэ ямар улсын үндсэн хуулийн заалт вэ?.....
 - Энэ үндсэн хуулийг хэдэн онд баталсан бэ?.....
 - Үндсэн хуулийн энэ заалт хэрэгжсэн үү?
19. Монгол улсыг “Бүгд найрамдах бүрэн эрхтэй ард улс” гэж нэрлэсэн Үндсэн хууль аль вэ?
- 1924 оны Үндсэн хууль
 - 1940 оны Үндсэн хууль
 - 1960 оны Үндсэн хууль
 - 1992 оны Үндсэн хууль
20. Бичвэрийг уншаад асуултад хариулж бичнэ үү.
 1937 оны 8 сарын 24-нд ЗХУ-ын нэр бүхий төрийн өндөр албан тушаалтнууд Японоос БНМАУ-ыг эзлэх төлөвлөгөө гэгчийг Монголын удирдагчдад танилцуулж нэгэн бичиг өгчээ. (Зөв хариулт бүр 1 оноо, нийт 3 оноо)
- Тэрхүү бичгийн нэр юу вэ?.....
 - Бичигт юу дурдсан байсан бэ?.....
 - Уг бичгийн хор уршиг юу вэ?
21. БНМАУ-д социализм байгуулахын тулд нэн тэргүүнд хэрэгжүүлсэн арга хэмжээ аль вэ?
- Үзэл суртлын талаар төөрөлдсөн сэхээтнийг зайлуулах
 - Социалист орнуудтай эдийн засгийн нягт хамтын ажиллагаа тогтоох
 - ЗХУ-аас материал техникийн туслалцаа авах
 - Боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын тогтолцоог бүрдүүлэх
 - Ардын аж ахуйтныг хөдөө аж ахуйн нэгдэлд хоршоолон нэгтгэх
22. Ардын Их Хурлын 1990 оны 5-р сарын чуулганаар Үндсэн хуулинд оруулсан нэмэлт өөрчлөлт аль вэ? (Зөв хариулт бүр 1 оноо, нийт 2 оноо)
- Хууль тогтоох, хянан шалгах, зохион байгуулах байнгын байгууллага нь УБХ байх
 - БНМАУ-ын Ерөнхийлөгчийн албан тушаал бий болгох
 - Засгийн газрыг Сайд нарын Зөвлөл болгох
 - Төрийн эрх барих дээд байгууллага нь УИХ байх
 - Улс төрийн олон намыг хүлээн зөвшөөрөх
23. Бичвэрт орхисон үгийг нөхөж бичнэ үү. (Зөв хариулт бүр 0,5 оноо, нийт 3 оноо)
 НТӨ 1792-1750 оны үед амьдарч асан улсын (*a. улсын нэр*) I хаанчлалын 6 дугаар хаан (*b. хааны нэр*) хуулийг Францын археологичид 1901 онд Суз хотоос олжээ. Уг дурсгалыг Парисын..... музейд (*c. музейн нэр*) хадгалж байна. Хуулийн эмхэтгэл зүйлтэй (*d. тоо*) боловч чулуун багана дээр 247 нь бүтэн үлджээ. Хожим НТӨ 660-630 онд төр барьж байсан Ассирын хаан.....(*e. хааны нэр*) номын сангаас уг хуулийн өөр нэг хувилбарыг олж, дутуу хэсгийг сэргээн нөхсөн юм. бичгээр (*f. бичиг үсэг*) бичсэн уг хууль удиртгал, үндсэн хэсэг, төгсгөлөөс бүрдэнэ.
24. Эх сурвалжийг уншин газар зүйн зургийг ажиглаад дараах 3 даалгаврыг гүйцэтгэнэ үү (Зөв хариулт бүр 1 оноо, нийт 3 оноо)

Эх сурвалж	Газар зүйн зураг
------------	------------------

Эх сурвалж 1.

1113 он. Нестор ламын бичсэн гэх “Он жилүүдийн тууж”-аас

“6370 он. Чудь, словен, мере, кривичи нар (зүүн славянчууд) тэнгисийн чанадад варягууд, русь нарт очив. Тэдгээр варяг өөрсдийгөө русь хэмээнэ. Харин зарим нь свеи, өөр нэг нь норманнчууд гэнэ. Чудь, словени, кривичи, весь нар русь нарт хандан “Манай газар өргөн уудам, гэвч тэнд хэв журам алга. Хаан сууж, биднийг захирна уу гэв. Ах дүү гурав сонгогдон (варягуудаас) овгийнхоо хамт ирцгээв. Том ах Рюрих....., нөгөө нь Белоозерод, гурав дахь нь Изборскт суув”.

Эх сурвалж 2.

“6390 оны зун. Олег ван их цэргээ авч, дайнд мордов.....хотын хаяанд ирээд Аскольд, Дир захиран суугааг мэдэв. Тэд нарт элч илгээн бид та нарын зочин Грект хүрэхээр яваа Олег ван, түүний хүү Игорь байна. Нутаг нэгт бидэндээ хүрэлцэн ирнэ үү гэв”



- Эх сурвалж 1-д гарч буй үйл явдал нийтийн тооллын хэдэн онд болсон бэ? Уг оныг зуунд шилжүүлнэ үү.
.....
- Эх сурвалж 2-т хотын нэрийг зургаас олж, өмнөх дугаарыг хоосон зайд бичнэ үү.
- Эх сурвалжид варяг, Грек гэж тухайн үеийн ямар ард түмэн, улсыг хэлсэн бэ?
.....

25.1789-1799 оны Францын хувьсгалын түүхэнд холбогдох зөв дүгнэлтийг ялгана уу. (Зөв хариулт бүр 0,5 оноо, нийт 3 оноо)

- 1789 оны 7-р сарын 14-нд босогчид Бастилын шоронг эзлэн авав
- 1792 он Францын хувьсгалын хуанлийн 1-р он юм
- Францын хувьсгалчид пуритан шашинтай байв
- Францчууд хувьсгал эхэлсэн 7-р сарын 4-ний өдөр Үндэсний баяраа тэмдэглэдэг
- Якобинчууд Францын хаан XVI Луиг (Людвиг) цаазлав
- Францын төрийн дуулал “Марсельеза”-г хувьсгалын үеэр зохиожээ
- Францын хувьсгалчид пресвитериан, индипендент гэх хоёр жигүүрт хуваагдав
- Францын хувьсгалын үеэр олон улсын жин хэмжүүрийн “Си тогтолцоо”-г нэвтрүүлэв
- Наполеон термидорын 9-ний төрийн эргэлтээр засгийн эрхэнд гарав

j. Францын хувьсгалын үеэр Наполеон Египетэд аян дайн хийв

26. Холбоотнуудын Ялтын бага хурлын талаарх зөв дүгнэлтийг ялгана уу. (Зөв хариулт бүр 1 оноо, нийт 3 оноо)

- a. Ялтын бага хурал 1945 оны 7-р сарын 17-8-р сарын 2-нд болсон
- b. Уг бага хурал ЗХУ-ын нутаг дэвсгэрт болсон
- c. Уг хуралд АНУ-ын ерөнхийлөгч Г. Трумэн оролцсон
- d. Уг хурлаас Европт II фронт нээх хугацааг тодорхойлсон
- e. Уг хурал АНУ-ын ерөнхийлөгч Ф. Рузвельт оролцсон Холбоотны дээд хэмжээний сүүлийн уулзалт байв
- f. ЗХУ Монголын статус-квог хүлээн зөвшөөрүүлэх болзол тавьсан

27. Дундад иргэн улсын түүхэн чухал үйл явдлыг он цагийн зөв дараалалд оруулна уу. (Зөв хариулт бүр 0.5 оноо, нийт 3 оноо)

- a. Умардын аян эхлэв.
- b. 5-р сарын 4-ний хөдөлгөөн өрнөв
- c. Япончууд Манжуурыг эзлэв.
- d. Хятадын коммунист нам байгуулагдав.
- e. Улаан армийн их аян (урт аян) өрнөв.
- f. Сунь Ятсен өвчний улмаас өөд болов.

1	2	3	4	5	6